

“Үр Дүнд Суурилсан Боловсрол”

үндэсний хөтөлбөрийн

танилцуулга

Хөтөлбөр боловсруулах ажлын хэсэг
М.Энхээ, БСШУСЯ
Н.Эрдэнэхүү, ШУТИС

Үр Дүнд Суурилсан Боловсрол (ҮДСБ)

Үндэсний хөтөлбөр боловсруулсан ажлын явц

- БСШУС-ын сайдын А-52 тушаалаар батлагдсан ажлын хэсэг бүрэлдэхүүнд
 - БСШУСЯ,
 - ХНХЯ,
 - БМИҮЗ,
 - БХүрээлэн,
 - МУИС, ШУТИС, ХААИС, АШУҮИС, МУБИС, Хүмүүнлэг ИС, ИЗОУИС-ийн төлөөлөл орсон
- 2017 онд хөтөлбөрийн төслийг боловсруулж их, дээд сургуулиуд, харьяа байгууллагуудын хүрээнд хэлэлцүүлсэн.
- 2018 оны 1 сард “Тогтвортой хөгжил-дээд боловсрол” улсын зөвлөгөөнд танилцуулж санал, зөвлөмж авсан.
- 2018 оны 4 сард БСШУСЯ-ны Дээд боловсролын бодлогын зөвлөлд танилцуулж, санал зөвлөмжийг тусгасан.

ҮДСБ үндэсний хөтөлбөр боловсруулах үндэслэл



Дэлхийн тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030



Боловсрол-2030 Инчёний тунхаг



Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл
баримтлал-2030



Боловсрол үндэсний хөтөлбөр: 2010-2021



Төрөөс боловсролын талаар баримлах бодлого:
2014-2024



Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр: 2016-2020



Дэлхийн дээд боловсролын хөгжлийн чиг хандлага

Дэлхийн тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030

- ❖ Дэлхийн тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг 2015 оны 9 дүгээр сард НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас баталсан. Тогтвортой хөгжлийн 17 зорилго, 169 зорилтыг дэвшүүлсэн.
- ❖ **Дэлхийн тогтвортой хөгжлийн IV зорилго:** “Хүртээмжтэй, тэгш чанартай боловсролоор хангах, хүн бүрийн насан туршдаа суралцах боломжийг дэмжих” ерөнхий зорилго. Тогтвортой хөгжлийн 17 зорилго, 169 зорилтыг дэвшүүлсэн байдал. Үүнд:
 - Боловсролын хүртээмж
 - Хүн бүр ялгаваргүйгээр боловсрол эзэмших боломж
 - Хүйсийн тэгш байдал
 - Боловсролын чанар
 - Насан туршийн суралцахий

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО




Боловсрол-2030 Инчёний тунхаг

- НҮБ, ЮНИСЕФ, Дэлхийн банк, UNFPA, UNDP, UNHCR зэрэг байгууллагууд хамтран 2015 оны 5 сард дэлхийн боловсролын форумыг Солонгосын Инчёнд зохион байгуулсан.
- Энд дэлхийн 160 орны 1600 төлөөлөгч оролцож дэлхийн тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 хөтөлбөрийн “Хүртээмжтэй, тэгш чанартай боловсролоор хангах, хүн бүрийн насан туршдаа суралцах боломжийг дэмжих” 4 дэх зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэсэн тунхаг гаргасан.
- “Боловсрол 2030” тунхаг нь тогтвортой хөгжлийн 4 дэх зорилгыг улс орон, бус нутаг болон дэлхийн түвшинд хэрэгжүүлэх удирдамж юм. Энэхүү баримт бичгийн:
 - I хэсэгт тогтвортой хөгжлийн 4 дэх зорилгын алсын хараа, зарчмыг тодорхойлсон;
 - II хэсэгт дэлхий нийтийг хамарсан зорилго, хүрэх үр дүнгийн 7 зорилт, хэрэгжүүлэх 3 арга зам, санал болгож буй стратегийн чиглэлийг тус тус танилцуулсан;
 - III хэсэгт хөтөлбөр хэрэгжүүлэх арга зам болох Засаглал, хариуцлага, түншлэл; Зохицуулалт; Хяналт, үнэлгээ, Санхүүжилт зэрэг асуудлыг тусгасан байна.

Тогтвортой хөгжлийн зорилго 4 ба бусад зорилгуудын хамаарал

Зорилт	Уялдаа	Зорилт	Уялдаа
TX3 1	Хүмүүс ядуурлаас ангижрахад боловсрол чухал үүрэгтэй.	TX3 10	Боловсрол тэгш хүртээмжтэй газар нийгэм, эдийн засгийн тэгш бус байдалд өөрчлөлт хийж чадна.
TX3 2	Хүмүүс тогтвортой ферм эрхлэх, хоол тэжээлийн ач холбогдлыг ойлгоход боловсрол чухал үүрэг гүйцэтгэнэ.	TX3 11	Боловсрол нь тогтвортой хотуудыг байгуулж, хөгжүүлэх, гамшиг ослын үед найдвартай байдлыг хангахад шаардагдах чадварыг хүмүүст бий болгоно.
TX3 3	Боловсрол нь эрүүл мэндийн олон асуудлууд, тухайлбал эрт нас барах, нөхөн үржихүйн эрүүл мэнд, өвчний тархалт, эрүүл, зөв амьдралын хэв маяг зэрэгт эрс өөрчлөлт гаргаж чадна.	TX3 12	Боловсрол нь үйлдвэрлэлийн загварт зарчмын өөрчлөлт хийх (эдийн засгийн эргэлт гэх мэт), бүтээгдэхүүний тогтвортой өсөлт, хог хаягдаас сэргийлэх зэрэгт эрс өөрчлөлт хийж чадна.
TX3 5	Бичиг үсэгт тайлагдах, оролцооны болон бусад чадвар, боломжоо нэмэгдүүлэх талаар охид, эмэгтэйчүүдэд боловсрол олгох нь нэн чухал байдаг.	TX3 13	Боловсрол нь уур амьсгалын өөрчлөлтийн үр дагавар, ялангуяа орон нутгийн түвшинд дасан зохицох, хариу арга хэмжээ авах талаарх олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх үндсэн эх сурвалж болно.
TX3 6	Боловсрол, сургалт нь байгалийн баялгийг илүү тогтвортой ашиглах, эрүүл ахуйг сайжруулах мэдлэг, бололцоог нэмэгдүүлнэ.	TX3 14	Боловсрол нь далайн хүрээлэн буй орчны талаар зөв мэдлэг ойлголт бий болгох, түүнийг ухаалаг бөгөөд тогтвортой ашиглахад нэн чухал үндэс болно.
TX3 7	Албан болон албан бус боловсролын хөтөлбөрүүд нь эрчим хүчийг хэмнэх, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлэхийг дэмжинэ.	TX3 15	Боловсрол, сургалт нь тогтвортой амьжиргааг хангах, байгалийн нөөц, биологийн төрөл зүйл, түүний дотор эмзэг нөхцөлд буй орчныг хамгаалах чадвар, чадавхийг нэмэгдүүлнэ.
TX3 8	Эдийн засгийн хөдөлгөөн, үйлдвэрлэл эрхлэх, хөдөлмөрийн зах зээлийн чадвар, боловсролын түвшин зэргийн хооронд шууд уялдаа холбоо байдаг.	TX3 16	Оролцоо бүхий, тэгш хамруулсан, шударга нийгмийг, мөн нийгмийн зохицол нэгдлийг хангах, дэмжихэд нийгмийн суралцахуй нь нэн чухал үүрэгтэй.
TX3 9	Тогтвортой үйлдвэржилт, найдвартай дэд бүтцийг байгуулахад шаардагдах чадварыг бүрдүүлэхэд боловсрол зайлшгүй чухал.	TX3 17	Насан туршийн суралцахуй нь тогтвортой хөгжлийн бодлого, практикийг ойлгох, хөхиүлэн дэмжих чадварыг бий болгоно.

Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030



А. Мөнхболд (2017) Монгол улсын тогтвортой хөгжлийг бодлого, www.nda.gov.mn

НҮБ-Тогтвортой хөгжлийн зорилго

Монгол Улсын ТХ-ийн үзэл
баримтлал-2030

Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын бүтэц

Монгол Улс 2030 онд нэг хүнд ногдох орлогоороо дунд орлоготой орнуудын тэргүүлэх эгнээнд хүрсэн, тогтвортой ёсч байгаа эдийн засгийн олон салбартай, нийгмийн хүрээнд дундаж болон чинээлэг дундаж давхарга давамгайлсан, экологийн тэнцвэртэй байдлыг хадгалсан, тогтвортой ардчилсан засаглалтай улс болно.



Зорилтуудыг хэрэгжүүлэх үе шатууд

I үе шат /2016-2020 он/
II үе шат /2021-2025 он/
III үе шат /2026-2030 он/

Хэрэгжилтийн явц, үр дүнг үндсэн 20 үзүүлэлтээр үнэлнэ.

Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал дахь дээд боловсролын хөгжлийн зорилтууд (1)

Зорилго: 2.2. Нийгмийн тогтвортой хөгжил

- 2.2.3. Мэдлэгт суурилсан нийгэм ба ур чадвар бүхий монгол хүн

Зорилт 4. Тогтвортой хөгжлийн зорилгыг хангахад чиглэсэн дээд боловсролын тогтолцоог хөгжүүлж, насан туршийн боловсролын тогтолцоог боловсронгуй болгоно.



Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал дахь дээд боловсролын хөгжлийн зорилтууд (2)



I-р үе
2016-2020

Зорилт 1.
Хүүхэд бүрийг стандартын шаардлага хангасан сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулах



Зорилт 2.
Ерөнхий боловсролын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх

Боловсролын олон улсын чанарын үнэлгээнд хамрагдах бэлтгэлийг хангах

Зорилт 3.
Мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог боловсронгуй болгох

Мэргэжлийн боловсрол, сургалтын багшах боловсон хүчинийг чадваржуулах

Зорилт 4.
Насан туршийн боловсролын тогтолцоог боловсронгуй болгох

Дээд боловсролын тогтолцоог тэгш, хүртээмжтэй чанартай болгох

Зорилт 5.
Шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн харилцан уялдааг хангаж, мэдрэгт суурилсан нийгмийг хөгжүүлэх

ШУ, технологийн судалгааны санхүүжилт ДНБ-д зэлэх хувь

2.0 %

II-р үе
2021-2025

Боловсролын олон улсын чанарын үнэлгээнд хамрагдах

Мэргэжлийн боловсрол, сургалтын эрэлтэнд нийцсэн тогтолцоог төлөвшүүлэх

Үндэсний 4-өөс доошгүй сургуулийг Азийн шилдэг сургууль болгох

2.5%

III-р үе
2026-2030

Боловсролын олон улсын чанарын үнэлгээнд байр ахиулах

Үндэсний ажиллах хүчиний хэрэгцээг ур чадвартай ажиллах хүчээр хангах

Олон улсын хөдөлмерийн зах зээлд хүлээн зөвшөөрөгдөх төгсгэгчид бэлтгэн гаргах

3.0%

Боловсрол үндэсний хөтөлбөр 2010-2021 (1)

“Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын баримт бичгийн **“Бүх нийтийн боловсролыг нийгмийн үйл хэрэг болгон хөгжүүлж, үндэсний боловсролын тогтолцоог олон улсын түвшинд ойртуулан төгөлдөржүүлж, оюунжсан, бүтээлч, чадамжтай хүний нөөцийг байнга нэмэгдүүлнэ.** “**Боловсрол**” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлэх зорилгоор 2010 онд засгийн газраас үндэсний хөтөлбөр баталсан байна. Хөтөлбөрийн хүрээнд дараах үндсэн зорилтыг хэрэгжүүлнэ:
Үүнд:

- Сургуулийн өмнөх болон бага, суурь боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлж, ерөнхий боловсролыг 12 жилийн сургалтын тогтолцоонд бүрэн шилжүүлэх;
- Дээд боловсролын шинэчлэлийг эрчимжүүлж, олон улсад өрсөлдөх чадвартай, олон улсын жишигт нийцсэн тогтолцоог бий болгох;
- Мэргэжлийн боловсрол, сургалтыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, дээд боловсролыг хөдөлмөрийн зах зээл, мэдлэг бүтээх эрэлтэд нийцүүлэн хөгжүүлэх;
- Албан бус боловсролыг шинэчлэн өргөтгөж, иргэдэд чиглэсэн бүх нийтийн насан туршийн боловсролын нээлттэй тогтолцоог төлөвшүүлэх.

Боловсрол үндэсний хөтөлбөр 2010-2021 (2)

Эдгээр зорилтуудын хүрээнд дээд боловсролын байгууллагын сургалттай холбоотой ямар гол гол үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэхээр төлөвлөж байсныг түүвэрлэн авч үзвэл:

Үүнд:

- ✓ Бүх шатны боловсролын агуулгын стандарт, төлөвлөгөө, хөтөлбөрт хуульд заасан хугацаанд үнэлгээ хийж, тэдгээрийг дэлхийн өндөр хөгжилтэй орны жишигт ойртуулан боловсронгуй болгох;
- ✓ Бүх түвшний боловсролын агуулгад тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санааг тусгах, үндэсний түүх, соёлыг бахархан дээдэлж, бусдын соёлд хүндэтгэлтэй хандах үзэл, бүтээлчээр сэтгэх мэдлэг, чадвар төлөвшүүлэх;
- ✓ Залуучуудад эх орон, ард түмнийхээ түүх, соёлоор бахархах үзэл, үндэсний соёлыг дээдлэх, бусдын соёлд хүндэтгэлтэй хандах хандлага төлөвшүүлэх;
- ✓ Бүх нийтийн англи хэлний сургалтын чанарыг дээшлүүлж, 2015 он хүртэлх хугацаанд дээд боловсрол эзэмшигчдийг ажил, мэргэжлийн шаардлагатай мэдээллийг англи хэлээр ашиглах чадвартай болгох;
- ✓ Багш бэлтгэх, мэргэшил дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх;

Боловсрол үндэсний хөтөлбөр 2010-2021 (3)

- ✓ Багш боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг шинэчлэн мөрдөж, уг мэргэжлээр суралцагчдын сургалтын чанарыг дээшлүүлэх арга хэмжээ авах;
- ✓ Багш бэлтгэдэг дээд боловсролын сургалтын байгууллагын багш нарын чадавхийг дээшлүүлэх;
- ✓ Багш бэлтгэдэг дээд боловсролын сургалтын байгууллагын сургалтын технологи болон материаллаг баазыг шинэчлэх ажлыг эрчимжүүлэх;
- ✓ Их, дээд сургуулийн багшийг чадавхижуулах тусгай хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;
- ✓ Дээд боловсролын сургалтын байгууллагад гадаадын өндөр хөгжилтэй орнуудаас нарийн мэргэжлийн судлаач багш урьж ажиллуулахыг дэмжих;
- ✓ Их, дээд сургуулийн судлаач багшийг гадаадад бэлтгэх, урт болон богино хугацааны сургалтад хамруулах;
- ✓ Дээд боловсролын сургалтын байгууллагад шинээр багшаар орж байгаа хүмүүст сургах зүйн боловсрол олгож, сургалтын агуулга, арга зүйг боловсронгуй болгох;
- ✓ Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын сургалтын орчныг тасралтгүй сайжруулах, төрийн бус өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын сургалтын орчныг сайжруулахад дэмжлэг үзүүлэх;
- ✓ Судалгааны их сургууль бий болгох суурь нөхцөлийг бүрдүүлж, өндөр хөгжилтэй орны их сургуулийн жишигт нийцэх судалгааны их сургуулийн хотхон байгуулах бодлогыг тодорхойлж, эрх зүйн орчныг бүрдүүлэх, санхүүжилтийг шийдвэрлэж, бүтээн байгуулалтын үйл ажиллагааг эхлүүлэх институцийг бий болгох;

Боловсрол үндэсний хөтөлбөр 2010-2021 (4)

- ✓ Дээд боловсролын эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, дээд боловсролын салбарын хүрээнд нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актуудыг боловсронгуй болгох;
- ✓ Дээд боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны чиглэл тус бүрт тавих хэм хэмжээг дэлхийн тэргүүлэх сургуулиудын түвшинг баримжаалан шинэчлэн тогтоох;
- ✓ Магадлан итгэмжлэлийн тогтолцоог шинэ шатанд гаргах;
- ✓ Дээд боловсролын стандартыг боловсронгуй болгох замаар чанарын дэвшил гаргах нөхцөлийг бүрдүүлэх;
- ✓ Дээд боловсролын чанарын удирдлагын тогтолцооны олон улсын туршлагыг дээд боловсролын салбарт нэвтрүүлэх санаачилгыг дэмжиж, чанарын үнэлгээний шинэ тогтолцоог бүрдүүлэх;
- ✓ Үндэсний тэргүүлэх мэргэжлийн чиглэлийг бодлогоор дэмжих эрх зүйн орчин бүрдүүлэх, авьяас билэгтэй оюутан, сурагчийг дэмжих арга механизмыг оновчтой болгох;
- ✓ Бэлтгэн гаргаж буй дээд боловсролтой мэргэжилтний тоо, чанарыг хөдөлмөрийн болон мэдлэг бүтээх эрэлтэд нийцүүлж, төгсөгчдийн ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах;
- ✓ Иргэдийн хэрэгцээнд тулгуурласан онлайн сургалтыг хөгжүүлэх;
- ✓ Ажилгүй хүмүүс, гэрийн эзэгтэй, өндөр настанд зориулсан мэргэжил олгох, дахин мэргэшүүлэх, хөгжүүлэх сургалт явуулах;
- ✓ Бүх шатны боловсролын нээлттэй болон зайны сургалтын төв байгуулж ажиллуулах

Төрөөс боловсролын талаар баримлах бодлого: 2014-2024 (1)

Энэхүү бодлогын баримт бичгийг 2015 онд баталсан бөгөөд “Иргэн бүр авьяас, чадвараа хөгжүүлэн, үр бүтээлтэй хөдөлмөрлөж, аз жаргалтай амьдрахад шаардагдах мэдлэг, чадвар, чадамжийг эзэмшин, ёс суртахуун, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахиж, үндэсний нийтлэг үнэт зүйлсийг өвлөн насан туршдаа суралцах боломжоор хангах зорилго бүхий үйл ажиллагааны цогц тогтолцоо бүрдүүлэхэд оршино” гэсэн зорилго дэвшүүлсэн байна.

Дээд боловсролтой холбоотой гол гол зорилтууд:

- Дээд болон мэргэжлийн боловсрол нь хөдөлмөрийн даяарчлагдсан зах зээлд амжилттай өрсөлдөх, бие даан ажлын байр бий болгох, улс үндэстний болон орон нутагт тулгамдаж байгаа асуудлыг үндэсний онцлогт тулгуурлан шийдвэрлэх, үндэсний инновацийн чадавхыг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулах чадамж эзэмших үе хэмээн хөгжүүлнэ (3.6);
- Дээд боловсролын байгууллагын судалгааны үйл ажиллагааг дэмжинэ (3.16);
- Дээд болон мэргэжлийн боловсролыг хөгжлийн бодлого, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлттэй уялдуулна (3.17);
- Бүх шатны боловсролын байгууллагын үйл ажиллагаанд өөрийн үнэлгээ, дотоод мониторингийн тогтолцоог хөгжүүлнэ (3.18);
- Бүх шатны сургалтын хөтөлбөр, агуулга, арга зүйд монголын түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч сэтгэлгээ, хувь хүний төлөвшил, хөгжил, хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлийг тусган хэрэгжүүлнэ (4.6);

Төрөөс боловсролын талаар баримлах бодлого: 2014-2024 (2)

- Дээд болон мэргэжлийн боловсролын сургалтын хөтөлбөрийг хөгжлийн бодлого, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, шинжлэх ухаан, технологийн дэвшил, иргэдийн сурах хэрэгцээ, ажлын байранд тавих шаардлагатай уялдуулан тасралтгүй хөгжүүлнэ (4.11);
- Дээд болон мэргэжлийн боловсролын чанарын баталгаажилт, магадлан итгэмжлэлийн тогтолцоог төгөлдөржүүлэх, олон улсын сургалтын хөтөлбөр, боловсролын зэргийг харилцан хүлээн зөвшөөрөх нөхцөлийг бүрдүүлнэ (4.12);
- Дээд болон мэргэжлийн боловсролыг олон улсын нийтлэг жишигийг баримжаалан төрөл бүрийн хэв шинжтэйгээр хөгжүүлнэ (4.13);
- Багшийн мэргэжлийн ур чадвар, нэр хүнд, ёс зүй, шаардлага, хариуцлагыг өндөржүүлэн, хөдөлмөрийг бодитой үнэлэх тогтолцоог бүрдүүлнэ (5.2).

Бодлогын хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтүүд:

- Боловсролын удирдлага, мэдээллийн нэгдсэн системийг 2016-2017 оны хичээлийн жилээс үндэсний хэмжээнд бүрэн нэвтрүүлсэн байна (7.11);
- Тэргүүлэх чиглэлийн дээд болон мэргэжлийн боловсролын 20-оос доошгүй хөтөлбөр олон улсад магадлан итгэмжлэгдсэн байна (7.12);
- Монгол Улсын дөрвөөс доошгүй их сургуулийг Азийн шилдэг 100 их сургуулийн эгнээнд хүргэсэн байна (7.13);
- Боловсролд мэдээллийн технологи, нээлттэй агуулга, хөтөлбөрийг хөгжүүлсэн байна (7.14).

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр: 2016-2020

3.2. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ: **Боловсролын чиглэлээр:**

- ❖ 3.2.9. Боловсролын түвшин, чиглэл тус бүрээр үнэлгээний систем, шалгуур, аргачлалыг хянан сайжруулж үйлчилгээний чанар, үр дүнг үнэлэх боломжтой болгоно.
- ❖ 3.2.10. Сургалтын стандарт, хөтөлбөр, сурах бичгийн агуулга, чанарыг дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага, өөрийн орны түүх, соёл, өв уламжлалд тулгуурлан шинэчилнэ.
- ❖ 3.2.18. Төрийн өмчит их, дээд сургууль, коллежийг хувьчлахгүй. Дээд боловсролын эрх зүйн орчинг боловсронгуй болгож, төрийн их, дээд суургуулийн бие даасан байдлыг нь хангах, **хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээг баримжаалсан мэргэжилтэн бэлтгэх, стандартад сууриссан чанарын хяналтын бодлого, төлөвлөлтийг хэрэгжүүлэх**, судалгаанд сууриссан их сургуулийг хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.
- ❖ 3.2.27. Нээлттэй мэдлэг, боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг үргэлжлүүлж, орчин үеийн мэдээлэл, технологийн ололтод тулгуурласан насан туршийн боловсролын тогтолцоог эрчимтэй хөгжүүлнэ.

Дэлхийн дээд боловсролын хөгжлийн чиг хандлага (1)

Юнескоогоос
гаргасан
боловсролын
4 тулгуурт загвар

Насан туршдаа суралцахуй

Мэдэхийн
тулд

Хийхийн
тулд

Байхын
тулд


Хамтдаа
амьдралын



1996 онд Делорийн илтгэлд тусгагдсан суралцахуйн үйл ажиллагааны зарчимд үндэслэн НҮБ-аас боловсролыг “Хүний сурч боловсрох нь бүхий л амьдралынхаа туршид эдлэх үндсэн эрх бөгөөд чанартай боловсрол эзэмшихэд хүн бүр тэгш эрхээр хангагдах ёстой” хэмээн тодорхойлсон байна.

Аливаа хүний ажлын амжилтын 85% нь хувь хүний хандлага, төлөвшил, уян хатан чадваруудаас, харин зөвхөн 15% нь техникийн мэдлэг, чадвараас шалтгаалдаг.

Эх үүсвэр: Харвардын их сургуулийн судалгааны үр дүн



Мэдлэг

Чадвар

Хандлага

Суралцахуйн
үр дүн

Эзэмшихэд хялбар

Эзэмшихэд хэцүү

Эзэмшихэд маш
хэцүү

Дэлхийн дээд боловсролын хөгжлийн чиг хандлага (2)




Оролтод суурилсан(Input-Based) эсвэл

Үйл явцад суурилсан(Process-Based) хэлбэрээс

Үр дүнд суурилсан(Outcome-Based) хэлбэр рүү шилжиж байна.

Үр дүнд суурилсан боловсролын тогтолцоо



ҮДСБ-ийн тогтолцоо бүхий Европын улсууд орнууд



ЕНЕА-ийн гишүүн Европын 48 улс

Эх сурвалж: <http://www.ehea.info/>

ҮДСБ-ийн CDIO санаачлагад нэгдсэн их, дээд сургуулиуд



ВАШИНГТОНЫ ГЭРЭЭНД НЭГДСЭН УЛС ОРНУУД

1. Австрали-[Engineers Australia \(EA\) \(1989\)](#)
2. Канад-[Engineers Canada \(EC\) \(1989\)](#)
3. Хятад-[China Association for Science and Technology \(CAST\) \(2016\)](#)
4. Тайвань-[Institute of Engineering Education Taiwan \(IEET\) \(2007\)](#)
5. Гонгконг-[Hong Kong Institution of Engineers \(HKIE\) \(1995\)](#)
6. Энэтхэг-[National Board of Accreditation \(NBA\) \(2014\)](#)
7. Ирланд-[Engineers Ireland \(EI\) \(1989\)](#)
8. Япон-[Japan Accreditation Board for Engineering Education \(JABEE\) \(2005\)](#)
9. Солонгос-[Accreditation Board for Engineering Education of Korea \(ABEEK\) \(2007\)](#)
10. Малайз-[Board of Engineers Malaysia \(BEM\) \(2009\)](#)
11. Шинэ зеланд-[Engineering New Zealand \(EngNZ\) \(1989\)](#)
12. Орос-[Association for Engineering Education Russia \(AEER\) \(2012\)](#)
13. Сингапур-[Institution of Engineers Singapore \(IES\) \(2006\)](#)
14. Өмнөд африк-[Engineering Council South Africa \(ECSA\) \(1999\)](#)
15. Шри-Ланк-[Institution of Engineers Sri Lanka \(IESL\) \(2014\)](#)
16. Турк-[Association for Evaluation and Accreditation of Engineering Programs \(MÜDEK\) \(2011\)](#)
17. АНУ-[Accreditation Board for Engineering and Technology \(ABET\) \(1989\)](#)
18. Англи-[Engineering Council United Kingdom \(ECUK\) \(1989\)](#)
19. Пакистан-[Pakistan Engineering Council \(PEC\) \(2017\)](#)
20. Багладеш-[Institution of Engineers, Bangladesh \(IEB\)](#)
21. Кост-Рика-[Colegio Federado de Ingenieros y de Arquitectos de Costa Rica \(CFIA\)](#)
22. Мексик-[Consejo de Acreditación de la Enseñanza de la Ingeniería \(CACEI\)](#)
23. Перу-[Instituto de Calidad Y Acreditacion de Programas de Computacion, Ingeneria Y Technologia \(ICACIT\)](#)
24. Филиппин-[Philippine Technological Council \(PTC\)](#)

“Үр Дүнд Суурисан Боловсрол”
үндэсний хөтөлбөр

ҮДСБ хөтөлбөрийн хамрах хүрээ



Үр Дүнд Суурисан Боловсрол үндэсний хөтөлбөрийн зорилго, зорилтууд

Хөтөлбөрийн зорилго:

Монголын Улсад суралцахуйн үр дүнд суурисан боловсролын стандарт, арга зүйг нэвтрүүлэх замаар дотоод, гадаадын хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээ, шаардлагыг хангасан дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэх тогтолцоог төлөвшүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

Хөтөлбөрийн зорилтууд:

Зорилт 1:

Үр дүнд суурисан боловсролын стандарт, арга зүйн дагуу сургалтын хөтөлбөр боловсруулах үйл ажиллагааг чанаржуулах

Зорилт 2:

Оюутан төвтэй суралцахуйн үйлийг дэмжсэн сургалтын орчин, нөөц бүрдүүлэх, цахим сургалтын технологийн хэрэглээг нэмэгдүүлэх

Зорилт 3:

Дээд боловсролын салбарын профессор, багш нарын мэргэжлийн болон заах арга зүйн чадамжийг дээшлүүлэх

Зорилт 4:

Суралцахуйн үр дүнг хэмжихүйц үнэлгээ, чанарын баталгаажуулалтын тогтолцоог хөгжүүлэх

Үр дүнд Сууринсан Боловсрол үндэсний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаанууд (1)

Үр дүнд сууринсан боловсролын стандарт, арга зүйн дагуу сургалтын хөтөлбөр боловсруулах үйл ажиллагааг чанаржуулах зорилтын хүрээнд:

1. Албан болон албан бус суралцахуйн үйлээр суралцагчийн эзэмшсэн мэргэшлийн мэдлэг, чадвар, хандлагын түвшинг тодорхойлж, баталгаажуулах Үндэсний Мэргэшлийн Хүрээг(УМХ-NQF)-г боловсруулж хэрэгжүүлэх;
2. XI зууны шинэ ажлын байрууд, одоо сургалт явуулж байгаа хөтөлбөр, мэргэжлүүдийн ирээдүйн чиг хандлагыг судлан монголын хөдөлмөрийн зах зээлд нэн шаардлагатай ажил мэргэжлийн жагсаалт, мэргэжилтний хэрэгцээг тодорхойлох;
3. Үр дүнд сууринсан боловсролын тогтолцоонд мөрдөх дүрэм, журам, бусад бичиг баримтуудыг боловсруулах;
4. Мэргэжлийн төрөлжсөн болон нарийвчилсан чиглэлээр төгсөн гарах мэргэжилтний мэдлэг, чадвар, хандлагын стандарт боловсруулж Стандартчилал хэмжил зүйн газраар батлуулах;
5. Дотоодын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн мэргэжлийн зөвлөлийн ангилалын дагуу сургалтын хөтөлбөрт тавих нарийвчилсан шалгуурууд(суралцахуйн үр дүнгийн жагсаалт гэх мэт..)-ыг боловсруулж мөрдөх;
6. “Үр дүнд сууринсан сургалтын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага”-ыг боловсруулж мөрдөх;
7. Дээд боловсролын байгууллагууд 4.1.5. ба 4.1.6-д тодорхойлсон шалгуур, шаардлагад нийцүүлэн бүх шатны сургалтын хөтөлбөрөө шинэчлэн боловсруулах;
8. Дээд боловсролын байгууллагуудын бүх шатны сургалтын хөтөлбөрт стандарт, шалгуур, шаардлагын дагуу үнэлгээ хийж боловсруулалтын түвшинг тогтоох ажлыг зохион байгуулах.

Үр Дүнд Сууринсан Боловсрол үндэсний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаанууд (2)

Оюутан төвтэй суралцахуйн үйлийг дэмжсэн сургалтын орчин, нөөц бүрдүүлэх, цахим сургалтын технологийн хэрэглээг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:

1. Оюутан төвтэй сургалтын үйл ажиллагааг дэмжсэн сургалтын орчинд тавих шаардлагыг боловсруулж хэрэгжүүлэх;
2. Дээд боловсролын байгууллагуудын сургалтын хөтөлбөрт байгаа төсөл, асуудал шийдвэрлэх даалгavar болон дадлага олгох хичээлүүдийн сургалтын орчин, тоног төхөөрөмж, техник хэрэгсэлийн бааз(Fabrication Laboratory гэх мэт)-ыг бүрдүүлэх;
3. Төгсөлтийн дараах сургалтад ашиглах орчин үеийн тоног төхөөрөмж бүхий өндөр технологийн сургалт, судалгааны лабораториудын тоог нэмэгдүүлж олон улсын түвшинд үнэлэгдэх судалгаа хийх орчин бүрдүүлэх;
4. Дээд боловсролын байгууллагуудын интернэт сүлжээний орчинг сайжруулж онлайн болон танхимиын сургалтыг хослуулан хэрэгжүүлэх, сургалтын удирдлага, мэдээллийн системийн ашиглалтыг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэх;
- ИДСургуулиудад нийтийн нээлттэй онлайн сургалт (МООС)-ын системийг байгуулж оюутнууд онлайн хэлбэрээр хичээл судлах, төгсөгчдийг богино хугацааны мэргэжил дээшлүүлэх болон ахисан түвшний сургалтанд хамруулах тогтолцоог бүрдүүлэх.

Үр Дүнд Суурисан Боловсрол үндэсний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаанууд (3)

Дээд боловсролын салбарын профессор, багш нарын мэргэжлийн болон заах арга зүйн чадамжийг дээшлүүлэх зорилтын хүрээнд:

1. Дээд боловсролын байгууллагын багшид тавих мэдлэг, чадвар, хандлага, ёс зүйн шаардлагуудыг тодорхойлж стандартчилах;
2. Дээд боловсролын байгууллагуудад “Багшийн хөгжлийн төв”-ийг байгуулж профессор багш нарыг тасралтгүй хөгжүүлэх, мэргэшил дээшлүүлэх тогтолцоог бүрдүүлэх;
3. Дээд боловсролын байгууллагын профессор, багш наарт үр дүнд суурисан сургалтын хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх, чанарын баталгаажуулалт хийх арга зүй эзэмшүүлэх зорилгоор сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах, сургалт зохион байгуулах;
4. Багаар ажиллах, харилцаа, ёс зүй зэрэг уян хатан(Soft skills) хандлага, чадваруудыг оюутнуудад хэрхэн эзэмшүүлэх арга зүйн зөвлөмж боловсруулах, багш наарт зориулж сургалт зохион байгуулах;
5. Орчин үеийн сургалтын идэвхитэй арга зүй, хэлбэрүүд болон мэдээлэл холбооны технологийг сургалтад хэрхэн ашиглах арга зүйн зөвлөмж боловсруулах, сургалт зохион байгуулах;
6. Профессор багш нарыг үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын дэвшилтэт тоног төхөөрөмжийн баазад дадлагажуулах замаар тэдний мэргэжлийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх тогтолцоог бүрдүүлэх;
7. “Нээлттэй боловсрол” цахим систем хөгжүүлж дээд боловсролын салбарын багш нарын мэргэжлийг дээшлүүлэх, харилцан туршлага солилцох зорилгоор ашиглах;
8. Профессор багш нарын Англи хэл дээр хичээл заах чадварыг хөгжүүлэх зорилгоор сургалтын тусгай хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;
9. Дээд боловсролын байгууллагын профессор, багш нарын сургалт, эрдэм шинжилгээ, олон нийтийн ажлын үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд бүхий чансаа тогтоох үнэлгээний нэгдсэн систем бий болгож хэрэгжүүлэх.

Үр Дүнд Сууринсан Боловсрол үндэсний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаанууд (4)

Суралцахуйн үр дүнг хэмжихүйц үнэлгээ, чанарын дотоод баталгаажуулалтын тогтолцоог хөгжүүлэх зорилтын хүрээнд:

1. Дээд боловсролын сургалтын байгууллагад чанарын дотоод баталгаажуулалт хариуцсан нэгж байгуулах нэгдсэн шаардлага боловсруулах, эрх зүйн орчинг бүрдүүлэх;
2. Хөтөлбөрийн болон хичээлийн суралцахуйн үр дүнгийн шууд ба шууд бус үнэлгээ, чанарын дотоод баталгаажуулалтын үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулах удирдамж, аргазүйн зөвлөмж боловсруулж хэрэгжүүлэх;
3. Ажил олгогчид, төгсөгчид, бусад оролцогч талуудаар хөтөлбөрийн суралцахуйн үр дүнд шууд бус үнэлгээ хийлгэх, тэднээс бүрдсэн мэргэжлийн зөвлөл байгуулж хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгийн хүрсэн түвшинг сайжруулах талаар санал, зөвлөмж авдаг тогтолцоог бий болгох;
4. Хөтөлбөр хариуцсан салбар, тэнхмүүд хичээлийн болон хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгийн үнэлгээг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлэх;
5. Чанарын дотоод баталгаажуулалтын албанаас хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгийн гүйцэтгэлд хөндлөнгийн үнэлгээ хийж сургалтын чанарыг баталгаажуулдаг тогтолцоог бий болгох;
6. Сургалтын удирдлага мэдээллийн системийг сургалтын чанарын дотоод баталгаажуулалтын гол хэрэглүүр болгон хөгжүүлэх;
7. Жил бүр чанарын дотоод баталгаажуулалтын тогтолцоог сайн хэрэгжүүлсэн сургуулиудыг шалгаруулж мэдээлэх, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулах;
8. Дээд боловсролын байгууллагын чанарын эрэмбэ тодорхойлох шалгуур үзүүлэлтүүд, арга зүйг тодорхойлж, их, дээд сургуулиудыг эрэмбэлэх, шилдэг сургууль, багш нарт дэмжлэг үзүүлэх тогтолцоог бий болгох.

Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүд (1)

Д/Д	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Зорилтот түвшин (2021 он)
Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогын хэрэгжилттэй уялдаатай шалгуур үзүүлэлтүүд			
1	Сургалтын удирдлага, мэдээллийн систем нэвтрүүлсэн сургуулийн эзлэх хувь	Хувь	100%
2	Дотоодод магадлан итгэмжлүүлсэн үр дүнд суурилсан сургалтын хөтөлбөрийн тоо	Тоо	60
3	Олон улсад магадлан итгэмжлэгдсэн тэргүүлэх чиглэлийн дээд боловсролын хөтөлбөрийн тоо	Тоо	20
4	Олон улсын эрэмбэ тогтоох байгууллагуудын шалгуур үзүүлэлтээр Азийн шилдэг 100 сургуулийн эгнээнд багтсан сургуулийн тоо	Тоо	1
Хөтөлбөрийн үр дүнг үнэлэх бусад шалгуур үзүүлэлтүүд			
1	Дээд боловсролын байгууллагуудын сургалтын хөтөлбөрийн мэргэжлийн төрөлжсөн болон нарийвчилсан чиглэлээр төгсөн гарах мэргэжилтний мэдлэг, чадвар, хандлагыг тодорхойлсон стандартын тоо	Тоо	60
2	Сургалтын хөтөлбөрт тавих нарийвчилсан шалгууруудыг боловсруулан мөрдөж байгаа хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн мэргэжлийн зөвлөлийн эзлэх хувь	Хувь	100%
3	Үр дүнд суурилсан сургалтын хөтөлбөрт тавих стандарт, шалгуур, шаардлагыг хангасан дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн эзлэх хувь	Тоо	100%
4	“Оюутан төвтэй сургалтын үйл ажиллагааг дэмжсэн сургалтын орчинд тавигдах шаардлага”-ыг хангасан анги, танхмын тоо	Тоо	90

Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүд (2)

Д/Д	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Зорилтот түвшин (2021 он)
Хөтөлбөрийн үр дүнг үнэлэх бусад шалгуур үзүүлэлтүүд			
5	Оюутнууд бие даан суралцах тусгайлсан орчин, тоног төхөөрөмж, техник хэрэгсэлийн бааз бүхий сургалтын хөтөлбөрийн тоо	Тоо	50
6	Магистр, докторын хөтөлбөрт сургалт, судалгааны зориулалтаар ашиглах шинээр байгуулсан лабораторийн тоо	Тоо	15
7	Мэргэжлийн болон мэргэшүүлэх хичээлийн агуулгыг сургалтын удирдлага, мэдээллийн системийн онлайн орчинд байршуулж хосолсон сургалт явуулж байгаа бүх шатны сургалтын хөтөлбөрийн эзлэх хувь	Хувь	60%
8	Байгууллагуудын интернэт сүлжээний хурд, хамрах хүрээг дээшлүүлэн цахим сургалтын сүлжээний орчин бүрдүүлсэн сургуулийн тоо	Тоо	15
9	Нийтийн нээлттэй онлайн сургалт(МООС)-ын системийг онлайн хэлбэрээр хичээл судлах, төгсөгчдийн богино хугацааны мэргэжил дээшлүүлэх болон ахисан түвшний сургалтанд ашиглаж байгаа сургуулийн эзлэх хувь	Хувь	100%
10	“Дээд боловсролын байгууллагын багшид тавих мэдлэг, чадвар, хандлага, ёс зүйн шаардлага”-ын стандартыг хэрэгжүүлж байгаа сургуулийн эзлэх хувь	Хувь	100%
11	Үр дүнд суурилсан боловсролын чиглэлд профессор, багш нарын заах арга зүйн чадамжийг дээшлүүлэх зорилгоор бэлтгэж хэвлүүлсэн сургалтын материал, арга зүйн зөвлөмж, гарын авлагын тоо	Тоо	40
12	Үр дүнд суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх, чанарын баталгаажуулалт хийх чиглэлээр дээд боловсролын байгууллагын багш нарын дунд зохион байгуулсан сургалтын тоо	Тоо	30

Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүд (3)

Д/Д	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Зорилтот түвшин (2021 он)
Хөтөлбөрийн үр дүнг үнэлэх бусад шалгуур үзүүлэлтүүд			
13	Үр дүнд суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх, чанарын баталгаажуулалт хийх чиглэлээр сургалтанд хамрагдаж сертификатын шалгуур хангасан дээд боловсролын байгууллагын багш нарын эзлэх хувь	Хувь	80%
14	Сургалтын идэвхитэй арга зүй, хэлбэрүүд, мэдээлэл холбооны технологийг сургалтад ашиглах арга зүйн чиглэлээр сургалтад хамрагдаж сертификатын шалгуур хангасан багш нарын эзлэх хувь	Хувь	70%
15	Аж ахуйн нэгж, байгууллагын дэвшилтэт тоног төхөөрөмжийн баазад сараас доошгүй хугацаагаар ажиллаж дадлага эзэмшсэн багшийн нарын тоо	Тоо	60
16	Дээд боловсролын салбарын “Нээлттэй боловсрол” цахим систем ашиглан бие даан заах арга зүйн чадвараа дээшлүүлж сертификатын шалгуур хангасан багш нарын тоо	Тоо	100
17	Англи хэл дээр хичээл зааж байгаа дээд боловсролын байгууллагын профессор багш нарын эзлэх хувь	Хувь	30%
18	Дээд боловсролын байгууллагын профессор, багш нарын ажлын үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд бүхий чансаа тогтоох үнэлгээний нэгдсэн системийг ашиглан багш нарын чансаа тогтоох, нийтэд мэдээлэх, урамшуулах тогтолцоог хэрэгжүүлдэг сургуулийн эзлэх хувь	Хувь	100%
19	Чанарын дотоод баталгаажуулалт хариуцсан нэгжийн үйл ажиллагаа нь жигдэрсэн дээд боловсролын байгууллагын эзлэх хувь	Хувь	100%

Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүд (4)

д/д	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Зорилтот түвшин (2021 он)
Хөтөлбөрийн үр дүнг үнэлэх бусад шалгуур үзүүлэлтүүд			
20	Чанарын дотоод баталгаажуулалт хариуцсан нэгжээс гаргасан заавар, зөвлөмжийн дагуу хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг үнэлэх төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлдэг, бүх шатны тайлан гаргаж хөтөлбөрийн сайжруулалтыг тогтмол хийдэг салбар, тэнхмийн эзлэх хувь	Хувь	100%
21	Ажил олгогчид, төгсөгчид, бусад оролцогч талуудаар хөтөлбөрийн суралцахуйн үр дүнд шууд бус үнэлгээ хийлгэдэг, сургалтын хөтөлбөрийн ангилалын дагуу ажил олгогчид, төгсөгчдөөс бүрдсэн мэргэжлийн зөвлөлтэй сургалтын хөтөлбөрийн тоо	Тоо	100
22	Сургалтын удирдлага мэдээллийн системийг суралцахуйн үр дүнд үнэлгээ хийх, статистик тайлан мэдээ боловсруулах чиглэлээр ашигладаг сургуулийн эзлэх хувь	Хувь	100%
23	Дотоод чанарын баталгаажуулалтын албанаас хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгийн гүйцэтгэлд хөндлөнгийн үнэлгээ хийж сургалтын чанарыг баталгаажуулдаг сургуулийн эзлэх хувь	Хувь	100%
24	Дээд боловсролын байгууллагуудын чанарын эрэмбэ тодорхойлох шалгуур үзүүлэлтүүдийн дагуу сургуулиудыг эрэмбэлэх системд холбогдсон сургуулийн эзлэх хувь	Хувь	100%

Үр дүнд суурилсан боловсрол үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат, санхүүжилт

Хөтөлбөрийг 2018-2021 онд дараах үе шаттай хэрэгжүүлнэ:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх бэлтгэл үе шат: 2018 он
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат: 2019-2020 он
- Хөтөлбөрийн биелэлтийг нэгтгэн дүгнэх, тайлагнах үе шат: 2021 он

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны эх үүсвэр:

- Улсын төсөв
- Дээд боловсролын сургалтын байгууллагын төсөв
- Олон улсын болон хандивлагч орнуудын зээл, тусlamжийн төсөл, хөтөлбөрийн санхүүжилт

Хөтөлбөрийн зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээ	Нийт (2018+2019+2 020+2021)	2018 он			2019 он			2020 он			2021 он		
		Нийт шаардагдах санхүүжилт	Ургал зардал	Хөрөнгө оруулалт									
Нийт шаардагдах хөрөнгийн хэмжээ	12,175.0	1,595.0	1,095.0	500.0	4,480.0	1,630.0	2,850.0	3,300.0	550.0	2,750.0	2,800.0	350.0	2,450.0
Улсын төсөв	5,780.0	-			2,330.0	480.0	1,850.0	1,900.0	250.0	1,650.0	1,550.0	150.0	1,400.0
Дээд боловсролын сургалтын байгууллагын өөрийн төсөв	5,080.0	280.0	280.0		2,150.0	1,150.0	1,000.0	1,400.0	300.0	1,100.0	1,250.0	200.0	1,050.0
Олон улсын болон хандивлагч орнуудын зээл, тусlamжийн төсөл, хөтөлбөрийн санхүүжилт(ДБШТ гэх мэт)	1,315.0	1,315.0	815.0	500.0	-						-		

ҮДСБ үндэсний хөтөлбөрийг 2018-2021 онд хэрэгжүүлэхэд нийт 12.175 тэрбум төгрөг шаардагдана.

**Анхаарал хандуулсанд
баярлалаа**